

Б.АТЛАВ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА А.ГАНЗУУЗАЙ



ДАЛАНЗАДГАД СУМАНД ЦЭЦЭРЛЭГИЙН БАРИЛГА БАРИХ АЖЛЫН ЗУРАГ
ТӨСӨВ БОЛОВСРУУЛАХ ДААЛГАВАР

2024.10.15

Дугаар ӨМДЗСДТГ/20240203081

Даланзадгад

1	Зураг төсөл боловсруулах үндэслэл:	Даланзадгад сум/хот/-ыг 2020-2024 онд хөгжүүлэх Засаг даргын үйл ажиллагааны “Дэвшилтэт Даланзадгад” хөтөлбөр, Даланзадгад сумын 2024 оны Хөгжлийн жилийн төлөвлөгөөний 29 дэх заалт
2	Барилга байгууламжийн байршил, газар олголтын шийдвэр:	Өмнөговь аймгийн Даланзадгад сумын Чандмань 9 дүгээр багийн нутаг дэвсгэрт.
3	Захиалагч байгууллага:	Даланзадгад сумын Засаг даргын тамгын газар
4	Зураг төслийн боловсруулахад ашиглах материал	<ul style="list-style-type: none">• Барилгын тухай хууль• Олон нийтийн барилгын норм ба дүрэм• Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүй норм• Монгол улсын барилгын норм ба дүрэм
5	Архитектур төлөвлөлт:	“Сургалт хүмүүжлийн барилгын зураг төсөл зохиох нэгдсэн норм” БНБД 31-24-22-ыг баримтлах. Барилга нь 200 хүүхдийн багтаамжтай байх ба 2 давхраас илүүгүй байна. Дэд бүтцийн шугамыг судалж төлөвлөх. Гадна тохижилтыг орчны барилга байгууламжуудтай уялдуулан нэгдсэн байдлаар төлөвлөх, Төлөвлөлтийн хязгаарын схем зургийн эргэлтийн цэгүүдийн солбилцолын дагуу төлөвлөлт хийх талбайд багтаан, зураг төслийг хийц архитектур төлөвлөлтийн шийдлийг бүрэн гаргаж боловсруулна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн орц, гарц пандусыг стандарт /MNS 6056:2009: 6055:2009/ болон норм дүрэм /Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орчны шаардлагад нийцсэн зураг төсөл зохиох норм БД 31-112-11/-н дагуу төлөвлөх, “Барилга, байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм” БНБД 21-02-02-г баримтлан барилгын зураг төслийг хийц архитектур төлөвлөлтийн шийдлийг бүрэн гаргаж боловсруулах, барилгын гадна гэрэлтүүлгийн шийдлийг тусгах, барилгад сэргээгдэх эрчим хүч ашиглах боломжийг судлах шаардлагатай.
	Хот төлөвлөлтийн онцгой нөхцөл	Чандмань 9 дүгээр багийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө баримт бичгийг баримтлан авто зам болон явган зам талбай, ногоон байгууламжтай уялдуулан нэгдсэн төлөвлөлт хийх, барилгын фасадыг орчны барилгуудын газар хөдлөлтөд тэсвэрлэх чадварыг

		<p>судалж “Газар хөдлөлийн бичил мужлалын чадварыг судалж “Газар хөдлөлийн бичил мужлалын зураг ашиглах норм ба дүрэм” /БНБД 22-04-16/ дүрмийг баримталж төлөвлөх, галын машин чөлөөтэй зорчих боломжийг гаргах, галын аюулаас хамгаалах шаардлагыг мөрдөх, гал илрүүлэх болон унтраах зориулалттай автомат систем төлөвлөх, одоо байгаа барилгын гал гэсвэрлэлт болон хийцтэлийн дүгнэлтийг үндэслэн төлөвлөж буй барилгад тохиромжтой хийцийг сонгон төлөвлөх, Инженерийн шугам сүлжээг хамгаалах, хүчитгэх арга хэмжээг зураг төсөлд тусгах, барилгын хаяг дугаар, дэлгээс зураг, нүүр тал, хажуу талуудын зураг дээр тусгах, нэг сурагчид ногдох эдэлбэр газрын хэмжээг норм дүрэмд нийцүүлэн төлөвлөх, Гадаргуугийн ус зайлуулах арга хэмжээг орчны барилгуудтай уялдуулж талбайн хэмжээнд иж бүрэн шийдэх</p>
6	Технологийн шийдэл:	<p>Олон нийтийн иргэний барилгын зураг төсөл боловсруулах, норм дүрэм болон одоогоор мөрдөгдөж буй холбогдох норм дүрмийг баримтлан сүүлийн үеийн дэвшилтэт шийдлүүдийг сонгох. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлчилгээ авахад саадгүй байх нөхцөл, боломжыг бүрдүүлж төлөвлөх</p>
7	Гүйцэтгэх ажлууд:	<p>Гүйцэтгэгч байгууллага гэрээ байгуулсны дараа тухайн барилгын захиалагч, ашиглагч байгууллагатай зөвшилцөж нэмэлт санал авна.</p> <p><u>Зургийн иж бүрдэл</u></p> <ol style="list-style-type: none"> 1. <u>Ерөнхий төлөвлөгөө-/ЕТ/</u> 2. <u>Барилга архитектур -/БА/</u> 3. <u>Технологийн байгуулалт -/ТХ/</u> 4. <u>Барилга бүтээц -/ББ/</u> 5. <u>Цахилгаан хангамж -/ЦХ/</u> 6. <u>Холбоо дохиолол –/ХД/</u> 7. <u>Халаалт, агаар сэлгэлт -/ХАС/</u> 8. <u>Цэвэр, бохир ус -/ЦБУ/</u> 9. <u>Хүчит төхөөрөмж -/ХТ/</u> 10. <u>Гадна шугам сүлжээ –/ГШС/</u> 11. <u>Геологийн дүгнэлт</u> 12. <u>Төсөв</u> 13. <u>Ажлын тоо хэмжээний жагсаалт</u> 14. <u>Магадлалын дүгнэлтүүд</u> 15. <u>Иж бүрэн магадлал хийгдсэн зураг, төсөв хүлээн авна.</u> <ul style="list-style-type: none"> • <u>Хэвлэмэл байдлаар 3 хувь</u> • <u>Хэвлэмэл байдлаар 3 хувь</u>

		<ul style="list-style-type: none"> • <u>CD байдлаар 1 хувь захиалагчид хүлээлгэн өгнө.</u> • <u>Ажлын зураг, төсвийг PDF форматаар cd-нд хавсаргах</u> • <u>Ерөнхий төлөвлөгөөг DWG форматаар cd-нд хавсаргах</u>
8	Барилгын үндсэн бүтээц, материал:	<p><u>Суурь:</u> Цутгамал төмөр бетон хийц <u>Арагт бүтээц:</u> Хөрсний болон байгалийн онцлогийг харгалзан, боломжит хийцлэлийг сонгох захиалагч байгууллагатай зөвшилцөх <u>Гадна хана:</u> Тоосго, шил, блок, цутгамал болон бусад дүүргэгч <u>Дотор хана:</u> Тоосго, блок, шил, бусад <u>Хучилт:</u> Цутгамал <u>Дээвэр:</u> Хавтгай дээвэр <u>Цонх:</u> Хуванцар, металл рамтай /вакуум/ шилэн цонх <u>Хаалга:</u> Шил, төмөр, модон хаалга</p>
9	Инженерийн хангамжийн эх үүсвэр:	Гадна инженерийн шугам сүлжээг бие даасан байдлаар шийдвэрлэх, боломжит нөхцөлийг судалж инженерийн хангамжийг олгогдсон техникийн нөхцөлийн дагуу төвлөрсөн шугам сүлжээнд холбогдох.
10	Зураг төсөл зохиох үе шат, хугацаа:	<p>Зураг төслийн үе шат:</p> <p>1. Зураг төсөл боловсруулах 1 үе шаттай байна. Хугацаа: Гэрээнд заасан хугацаанд</p> <p>Зураг төсөл, төсөв, холбогдох баримт бичиг нь монгол хэл дээр байна. Гадаад хэл дээр байгаа тоног төхөөрөмж, техник технологийн баримт бичгийн бичвэрийг монгол хэл рүү орчуулна.</p>
11	Хөрөнгийн эх үүсвэр:	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
12	Онцгой нөхцөл:	<ul style="list-style-type: none"> • Зураг төсөл гүйцэтгэгч байгууллага тухайн барилгыг төлөвлөж буй байршил дээр очиж газар дээр нь хангагч байгууллагатай зөвшилцөн техникийн нөхцөлийг баталгаажуулж авна. /дэвсгэр зургийн тодруулга заавал хийсэн байна./ • Техникийн нөхцөлийн төлбөрийг зураг төсвийн үнэд багтсан гэж захиалагчаас үзэх бөгөөд техникийн нөхцөлийг гаргаж өгсөн тухайн хангагч байгууллагын нэхэмжлэхийг үндэслэнэ. • Барилгын аврах гарцыг норм дүрмийн дагуу төлөвлөх ба саадгүй, түргэн аврах гарцыг төлөвлөх • Барилга болон бага, дунд, ахлах бүлгүүдийн онцлогийг архитектур орон зайн өвөрмөц шийдлийг тусгах • Багш болон сурагчдын анги танхимын зориулалтаас хамааруулан мэдээлэл харилцаа,

		<p>холбоо дохиоллын инженерийн шугам сүлжээний хэрэгцээ шаардлагыг хангахуйц төлөвлөх</p> <ul style="list-style-type: none"> • Газар хөдлөлтийн бүс нутаг барилга төлөвлөх барилгын норм ба дүрэм БНБД 22-01-01-ийн 2.5-ын • Галд шатах материал барилгын үндсэн хийцэд ашиглахгүй байх
13	Галын аюулгүй байдлын нөхцөл:	Барилга байгууламжийн галын аюулгүй байдал БНБД21-01-02, Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм БНБД21-02-02-ийн холбогдох шаардлагуудыг хангасан байх
14	Эдийн засгийн тооцоо, төсөв, ТЭЗҮ:	Тухайн барилгад зарцуулагдах хөрөнгө оруулалтын хэмжээг барилгын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан төсөв зохиох дүрэм журмын дагуу тооцож гаргах

БОЛОВСРУУЛСАН:

ДЭД БҮТЭЦ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ОРОН НУТГИЙН
ХӨГЖЛИЙН САНГИЙН ТӨЛӨВЛӨЛТ ХАРИУЦСАН
БОДЛОГЫН МЭРГЭЖИЛТЭН



Ч.ЛХАГВАЦЭРЭН